



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

XII. ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын орлогоос дээд шатны байгууллагын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг арилгах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Эрчим хүчний сайдын 2017 оны 50 дугаар тушаалаар баталсан “... тусгай зөвшөөрөл, цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтын хураамжийг зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу 2017 онд Эрчим хүчний яамны 274.9 сая төгрөгийн, 2018 онд 161.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Тусгай зөвшөөрлийн тухай хууль, “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн байх тул Эрчим хүчний сайдын 2017 оны 50 дугаар тушаалд өөрчлөлт оруулах зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх нь зүйтэй”. гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000049